



**ОРХОН АЙМГИЙН  
ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ**

2017 оны 03 сарын 10 өдөр

Дугаар А/111

Эрдэнэт

Г Хөрөнгө бүртгэлд авах тухай Г

Монгол улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.2 /г/, 29.2, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 78 дугаар зүйлийн 78.2.1, 78.2.4, аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн хурлын Тэргүүлэгчдийн 2013 оны 157 дугаар тогтоолоор баталсан "Орон нутгийн өмчит хуулийн этгээд үндсэн хөрөнгө олж авах, бүртгэх, худалдах, шилжүүлэх, актлах журам"-ын 3.1 дэх заалт, Монгол улсын дээд шүүхийн хяналтын шатны захиргааны хэргийн шүүх хуралдааны 2015 оны 10 дугаар сарын 19-ний өдрийн 275 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Шүүхийн шийдвэрээр Орон нутгийн өмчлөлд шилжин ирсэн 16,400,000 төгрөгийн 20x12 м<sup>2</sup> бүхий өвс тэжээлийн агуулах, 27,908,629 төгрөгийн 10,000 м<sup>2</sup> агуулахын бетон хашаа, 15,166,622 төгрөгийн царгасны өргөст торон хашааг Баян-Өндөр сумын Засаг даргын Тамгын газрын үндсэн хөрөнгөд бүртгэхийг зөвшөөрсүгэй.

2.Захирамжийн хэрэгжилтэнд хяналт тавин ажиллахыг Орон нутгийн өмчийн газар /н.Оюунгэрэл/-т, байгууллагынхаа хөрөнгө, санхүүгийн бүртгэлд зохих журмын дагуу өөрчлөлт оруулах, хөрөнгийн цаашдын ашиглалт, хадгалалт, хамгаалалтыг хариуцан ажиллахыг Баян-Өндөр сумын Засаг даргын Тамгын газрын дарга, нягтлан бодогч нарт даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



Д.БАТЛУТ